

Улсын бүртгэлийн
дугаар

Нууцын зэрэглэл Б

Аравтын ангиллын
бүрэн код

Төсөл хэрэгжүүлэх
гэрээний дугаар № ШyCc_2017/21

**“ТОРГОН ЗАМЫН ХӨГЖИЛД ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ГҮЙЦЭТГЭСЭН
ҮҮРЭГ (VI-XVI ЗУУН)”
СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ТАЙЛАН
(2017-2019)
(2017-2019 он. № ШyCc_2017/21.)**

Төслийн удирдагч: С.Цолмон, доктор (Ph.D), профессор
ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эзэнт
Гүрний салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх
ажилтан

Санхүүжүүлэгч байгууллага: Шинжлэх Ухаан Технологийн Сан

Захиалагч байгууллага: Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

Тайланг өмчлөгч байгууллага: ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

Улсын бүртгэлийн дугаар
Санхүүжүүлэгч байгууллага: Шинжлэх Ухаан Технологийн Сан
Тайланг өмчлөгч байгууллага: ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн

**“ТОРГОН ЗАМЫН ХӨГЖИЛД ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ГҮЙЦЭТГЭСЭН
ҮҮРЭГ (VI-XVI ЗУУН)”
СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ТАЙЛАН
(2017-2019)**

Төслийн удирдагч: С.Цолмон, доктор (Ph.D), профессор
ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эзэнт
гүрний салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх
ажилтан

Төслийн гүйцэтгэгчид: Л.Мөнхбаяр, магистр
Ц.Төрбат, доктор (Ph.D), профессор
А.Энхтөр, доктор (Ph.D), дэд профессор
Р.Мөнхтулга, доктор (Ph.D),
Г.Батболд магистр
С.Хүрэлсүх
Т.Батбаяр
Ц.Цэрэндорж
Ц.Энхчимэг, доктор (Ph.D), профессор
А.Пунсаг, доктор (Ph.D), профессор
Л.Ганбат, доктор (Ph.D)

Төсөл гүйцэтгэгч байгууллагын хаяг: 13343 Улаанбаатар,
Баянзүрх дүүрэг, Жуковын гудамж 77,
Утас: +976-11-458305, +976-11-455028

Улаанбаатар
2019


"Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг (VI-XIV зуун)" нэртэй суурь судалгааны төслийг хэрэгжүүлэх, гэрээг үргэлжлүүлэх, тус төслийн хүрээнд 2017 оны 09 дугаар сарын 09-ны өдрийн дугаар гэрээний 1 дүгээр хавсралт

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

/Техникийн даалгавар/

д/д	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа (он, сар)
1.	"Их Торгон замын умард сүлжээ" нэртэй хамтын бүтээл хэвлэлийн эх бэлэн болно.	(15х.х)	Хамтын бүтээлийн хэвлэлийн эх бэлтгэх	2017-2019 онд
2.	"Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг" хамтын бүтээлийн хэвлэлийн эх бэлэн болно.	(20х.х)	Хамтын бүтээлийн хэвлэлийн эх бэлтгэх	2017- 2019 онд
3.	"Торгоны зам ба нүүдэлчдийн соёл" олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийн эх бэлэн болно.	(10х.х)	Олон улсын эрдэм шинжилгээний эмхэтгэлийн эх бэлтгэх	2019
4.	Эцсийн тайланг хүлээлгэн өгөх	1	Эцсийн тайланг боловсруулж, судалгааны ажлын үр дүн, бүтээгдэхүүнүүдийг хүлээлгэн өгнө.	2019 оны 12 сард багтаана.


Захиалагчийг төлөөлж:


/гарын үсэг/

Т.Ган-Эрдэнэ
/овог, нэр/

БСШУСЯ-ны ШУТБГ -ын дарга
/албан тушаал/

Санхүүжүүлэгчийг тодоолж:


/гарын үсэг/

Д.Энхжаргал
/овог, нэр/

ШУТСангийн Захирал
/албан тушаал/

Гүйцэтгэгчийг төлөөлж:


/гарын үсэг/

С.Чулуун
/овог, нэр/

Түүх,Археологийн хүрээлэнгийн захирал
/албан тушаал/

Төслийн удирдагч:


/гарын үсэг/

С.Цолмон

/овог, нэр/
Түүх,Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

/албан тушаал/

АГУУЛГА

I. Суурь судалгааны төслийн ажлын үр дүнгийн тайлан

II. Төсөлт ажлаар гүйцэтгэсэн хамтын бүтээлүүд, эрдэм шинжилгээний хурлын танилцуулга

1. “Их Торгон замын умард сүлжээ” (VI-XVI зуун) хамтын бүтээл. (15х.х.) (Гүйцэтгэгч Л.Мөнхбаяр, Ц.Төрбат, А.Энхтөр, Р.Мөнхтулга, Г.Батбаяр, Г.Батболд)
2. “ Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” (XIII-XVI зуун) /20х.х/
3. “Эрт, дундад үеийн Евразийн нэтворкийн сүлжээн дэх Монгол он”эрдэм шинжилгээний каталоги (24 х.х)

III.Төсөлт ажлаар гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний өгүүллүүд

IV. Төсөлт ажлаар гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний илтгэлүүд

V. Хавсралт. 2017-2019 онд хийсэн археологийн судалгааны товч тайлан

“ТОРГОН ЗАМЫН ХӨГЖИЛД ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ (VI-XVI ЗУУН)”

суурь судалгааны сэдэвт ажлын үр дүнгийн тайлан
(2017-2019)

1.Төслийн тодорхойлолт: “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” (VI-XVI зуун) суурь судалгааны сэдэвт ажил нь БСШУ-ны сайдын тушаалаар батлагдаж, төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх ШуСс_2017/21 дугаартай гэрээг 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан болно.

Суурь судалгааны төслийн ажил ШУА-ийн Түүх, археологийн (угсаатны зүйн) хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарт 2017-2019 онд хэрэгжив.

Төслийн гэрээний дагуу суурь судалгааны ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, гүйцэтгэх ерөнхий удирдлагыг хүрээлэнгийн захиргаа хангаж, “Үр дүнгийн даалгавар”-т тусгагдсан ажлыг жил бүрийн Календарьчилсан төлөвлөгөөний дагуу явуулах үүргийг сэдвийн удирдагч хүлээж, хэрэгжилт, явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.

Суурь судалгааны төсөлт ажлыг доктор (Ph.D), профессор 6, доктор (Ph.D), дэд профессор 2, доктор 2, магистр 2, нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэв. Төслийн үр дүнг Шинжлэх Ухааны Академийн Нийгмийн ухааны салбарын бага чуулганы 2020 оны хуралдаанаар хэлэлцэн үр дүнг хангалттай гүйцэтгэсэн гэж шийдвэрлэсэн.

2.Төслийн зорилго:

Евразийн удам тал нутгийг хамарсан их Торгон замын олон зууны түүхийг дэлхийн олон эрдэмтэд олон шинжлэх ухааны зааг уулзварт тал талаас нь нухацтай судалсан боловч Торгон замын хөгжилд монголчуудын оролцоо, хувь нэмрийн тухай асуудал бараг судлагдаагүй орхигдсон гэж үзэж болно. Энэ нь 1990-ээд оноос өмнөх түүх бичлэгт Чингис хаан болон Монголын эзэнт гүрний түүхийг судлах нь хязгаарлалттай байсантай холбоотой.

Тиймээс “Торгон замын хөгжилд умардын нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр”(VI-XVI зуун) суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд Торгон замын хөгжил дэх монголчуудын оролцоо, тэдний оруулсан хувь нэмрийг тодруулан гаргахыг зорьсон юм.

3.Суурь судалгааны төслийн хэрэгжилт: Төслийн судалгааны гүйцэтгэлийг он тус бүрээр авч үзвэл:

2017 онд “Календарьчилсан төлөвлөгөө”-ний дагуу Төслийн даалгаварт тусгагдсан

- 2 хамтын бүтээлийг бичих эх хэрэглэгдэхүүн цуглуулах (30 х.х.),
- зохиолуудыг бичих үзэл баримтлал, төлөвлөгөөг боловсруулах,
- гадаад хэлээр буй эх хэрэглэгдэхүүнийг орчуулах
- археологийн малтлага судалгаа хийх,
- эрдэм шинжилгээний 3 илтгэл, 3 өгүүлэл, археологийн хээрийн шинжилгээний тайлан бичихээр тус тус төлөвлөж биелүүлэв.

Гүйцэтгэл:

а/ Нийт 30 х.х. баримт, эх хэрэглэгдэхүүн цуглуулан, 2 хамтын бүтээлийн бүтцийн төлөвлөгөөг гаргаж, нэг бүтээлийг бичих ажлыг эхлүүлэв.

б/ Судалгааны завсрын үр дүнгээр эрдэм шинжилгээний 3 өгүүлэл бичиж, дотоод, гадаадын эрдэм шинжилгээний хурал, хүрээлэнгийн онол арга зүйн семинарт 3 илтгэл хэлэлцүүлжээ.

в/ Монгол улсын төвийн бүс нутаг Төв, Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгийн нутаг дахь эрт, дундад үеийн хот сууринууд, тэдгээрийн ойр орчмын дурсгалт газруудад археологийн малтлага судалгааг хийв.

2018 онд “Календарьчилсан төлөвлөгөө”-ний дагуу

- судалгааны эх хэрэглэгдэхүүн (35 х.х) нэмэн цуглуулах,
- гадаад хэлээр буй эх хэрэглэгдэхүүнийг орчуулах (5 х.х),
- археологийн малтлага судалгаа хийх, бүтээлүүдийн дэлгэрэнгүй төлөвлөгөө, үзэл баримтлалыг хэлэлцэн батлах, зарим зохиолын бүлэг, зүйлийн бичлэгийг хийх, эрдэм шинжилгээний 5 өгүүлэл мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх, эрдэм шинжилгээний илтгэл 6-г олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд тавьж хэлэлцүүлэх

Гүйцэтгэл:

а/ 35 х.х. баримт, эх хэрэглэгдэхүүн цуглуулж, орчуулав.

б/ 2 хамтын бүтээлийг бичих ажлыг эхлүүлэн зарим бүлэг, зүйлийн эхний бичлэг (10 х.х.) -ийг хийж, завсрын үр дүнгээр эрдэм шинжилгээний 5 өгүүлэл бичиж мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн ба гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд 10 илтгэл хэлэлцүүлэв.

в/ Булган, Өвөрхангай аймгийн нутаг дахь эрт, дундад үеийн хот сууринууд, тэдгээрийн ойр орчмын дурсгалт газруудад археологийн малтлага судалгааг хийв.

2019 оны “Календарьчилсан төлөвлөгөө”-ний дагуу

- Сэдэвт ажилд хамрагдах хамтын бүтээлүүдийг бичиж дуусган, Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, зохих засвар хийх (2 бүтээл, 1 эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл),
- Эхний бичлэгийг засч сайжруулах, салбарын хурлаар хэлэлцүүлэх, эрдэм шинжилгээний 5 өгүүлэл, 6 эрдэм шинжилгээний илтгэл хуралд тавих.

Гүйцэтгэл:

1. “Төслийн үр дүнгийн даалгавар” ёсоор 2 хамтын бүтээлийг бичиж дуусгасан ба 1 эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж илтгэлийн эмхэтгэлийг хэвлүүлэхэд бэлэн болгож Хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн болно.

2. Сэдэвт ажлын хүрээнд эрдэм шинжилгээний 5 өгүүлэл бичиж, эрдэм шинжилгээний хурлын илтгэл 13-ийг хэлэлцүүлэв.

4. Суурь судалгааны төсөлт ажлын үр дүн: Гэрээний дагуу “Төслийн даалгавар”-т тусгагдсан ажлуудыг бүрэн биелүүлэв. Үүнд:

1.Хамтын бүтээл 2, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 1-ийг туурвив.

2. Төслийн гэрээнд 13 өгүүлэл бичихээр тусгагдсанаас 15 өгүүлэл бичиж 13-ийг хэвлүүлж 2 нь хэвлэлтэнд өгсөн байна.

3. Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний хуралд 15 илтгэл хэлэлцүүлэхээр тусгагдсанаас 29 илтгэл хэлэлцүүлэв.

4. Төслийн ажлын үр дүнг 2020 оны 5 сарын 20-нд Шинжлэх Ухааны Академийн Нийгмийн ухааны салбарын Бага чуулганаар хэлэлцүүлж “Тус суурь судалгааны баг төслийн зорилго, зорилт болон үр дүнгийн даалгаврыг хангалттай сайн биелүүлсэн үнэлгээ авсан болно.

Төслийн судалгаагааны үр дүнг Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

“Төслийн даалгавар”		Төслийн судалгааны явцад нэмэгдэж хийгдсэн ажил
Гүйцэтгэх ажил	Биелэлт	
1.“Их Торгон замын умард сүлжээ” (VI-XVI зуун). Хамтын бүтээл	/15 х.х./	Бичсэн /15 х.х./

	<p>2. Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг (XIII-XVI зуун)</p>	<p>/20х.х./</p>	<p>Бичсэн /20 х.х./</p>	
	<p>3. “Торгон зам ба нүүдэлчдийн соёл” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж илтгэлүүдийн эмхэтгэлийн эхийг хэвлэлд бэлэн болгоно. Эмхэтгэлийн эхийг хэвлэхэд бэлэн болгох</p>	<p>/10х.х./</p>	<p>Эхийг хэвлэлд бэлэн болгосон /12 х.х./</p>	<p>1.2018 оны 7 сарын 15-наас 17-нд Өвөрхангай аймагт НҮБ-ийн ЮНЕСКО-гоос санал тавьсны дагуу “Торгон замын дагуух улс орнуудын олон улсын соёлын харилцан нөлөөлөл, харилцан үйлчлэлийн Атлас”-т орох нүүдэлчдийн хоол хүнс, гастрономын асуудлаар ярилцах ЮНЕСКО-гийн олон улсын экспертүүдийн уулзалт ярилцлагыг зохион байгуулсан ба тус хуралд Азербайджан, БНХАУ, Франц, Турк, Грек, ОХУ, Узбекистан, Казакстан,</p>

				<p>Энэтхэг, БНСУ, Монгол, Иран зэрэг орны 20 гаруй эрдэмтэн, шинжээчид оролцож Торгоны зам дагуух улс орнуудын хоол хүнсний үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг хэлэлцсэн.</p> <p>Энэхүү арга хэмжээнд зориулж “Эрт, дундад үеийн Евразийн нэтворкийн сүлжээн дэх Монгол орон” эрдэм шинжилгээний каталоги /24 х.х/-ийг монгол, англи хэлээр хэвлүүлэв.</p> <p>2. Архангай аймагт 2018 оны 7 сарын 17-19-нд “Торгон зам ба нүүдэлчид” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монголын ЮНЕСКО-ийн Үндэсний комисс, Нүүдлийн соёл иргэншил судлах хүрээлэн, Олон улсын Монгол судлалын Холбоо, УИХ-ын Тамгын газартай хамтран зохион байгуулсан ба тус хуралд Канад, ОХУ, Узбекистан, БНХАУ, Иран, Франц, Монгол улсын эрдэмтэн, шинжээчид оролцов. Төслийн багаас С.Цолмон, Ц.Төрбат, А.Энхтөр нар илтгэл тавьж хэлэлцүүлэв. “Silk Road and Nomads” хурлын эмхэтгэлийг англи хэлээр хэвлүүлсэн болно. /10х.х/</p>

	Эрдэм шинжилгээний өгүүлэл	13	Бичсэн 15 Үүнээс хэвлэгдсэн 13	
	Эрдэм шинжилгээний хурлын илтгэл	15	29	

**II. ТӨСӨЛТ АЖЛААР ГҮЙЦЭТГЭСЭН
ХАМТЫН БҮТЭЭЛ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

1. “Их Торгон замын умард сүлжээ” (VI-XVI зуун) хамтын бүтээлийг бичиж дуусгав. (137 нүүр.) (Гүйцэтгэгч Л.Мөнхбаяр, Ц.Төрбат, А.Энхтөр, Р.Мөнхтулга, Г.Батбаяр, Г.Батболд,)

“Их Торгон замын умард сүлжээ” (VI-XVI зуун) /15х.х./

Эрхэлсэн Д.Цэвээндорж

Хамтын бүтээл нь Удиртгал, гурван бүлэг, төгсгөлт хэсгээс бүрднэ. Бүтэц нь дараах байдалтай.

УДИРТГАЛ: ТОРГОН ЗАМ БА МОНГОЛ ОРОН

Л.Мөнхбаяр. “Торгон зам” хэмээх нэрийн учир

Ц.Төрбат. Торгон замын түрүү үе

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: УЙГУРЫН ҮЕ

А.Энхтөр. Уйгурын үеийн Торгон замын салаануудын тухай

Т.Батбаяр. Уйгурын нийслэл Хар Балгасаас олдсон Торгон замын холбогдолт олдворууд

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХЯТАНЫ ҮЕ

А.Энхтөр. Хятаны улсын үеийн Торгон замын умард сүлжээ

Г.Батболд. Шивэй аймгийн нэр ба Талын Торгон зам

Т.Эрдэнэцогт, Г.Батболд. Өмнөговь аймгийн нутаг дахь “Чингисийн далан”, түүний түүхэн цаг хугацааг нягтлах нь

ГУРАВДУГААР БҮЛЭГ: МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ҮЕ

С.Хүрэлсүх. Торгон зам ба хадны оршуулга

Р.Мөнхтулга. Торгон зам ба Цагадайн улсын соёл


ТӨГСГӨЛ

Уг хамтын бүтээлийг туурвихад Төв, Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгийн нутагт хээрийн шинжилгээний ажлыг дрон зэрэг техник, технологийн шинэ арга зүйг ашиглан агаарын зураг үйлдэж монгол нутаг дахь эртний хотуудын байршил, зураглалыг нягтлан тодруулж, тэдгээрийг холбосон замын зураглал гаргаж тэдгээр замууд нь хэрхэн торгон замтай холбогдож байсан маршрутыг тогтоолоо.

Мөн энэхүү шинэ эх хэрэглэгдэхүүн, зураглалуудаар мэдээллийн баазыг бүрдүүлсэн ба энэ нь цаашдын судалгаагаар баяжигдан археологийн судалгааны мэдээллийн сан болох үндэс суурь болох юм. (Хээрийн шинжилгээний тайлангийн товчийг хавсаргав.)

Судалгаагаар тогтоогдсон замын маршрутыг газрын зурагт буулгаснаар:

1. Түрэгийн үеийн худалдааны замын маршрут:



1.Ховдын Үенч сумын нутаг дахь Ямаан Усны хавцлаар нэвтрэн урагш говийн бүс рүү уруудах зам

2.Улиастайгаас Торгон зам хүрэх өөр нэг зам нь арай зүүнтээгүүр, Алтайн нурууг зүүн хойноос баруун урагш давах тодруулбал Улиастайгаас урагш 140-өөд км-т буй, Говь-Алтай аймгийн Тайшир сумын Бэрх уул, мөн аймгийн Бигэр сумын төвөөс баруун урагш 17 км-т орших Хар Аараг, бас Бигэрийн төвөөс урагш 15 км-т буй Алтан хад, тэндээс Гичгэний нурууны ар дахь Чандмань сумын Шаахар толгой хүрдэг байв. Шаахар толгойгоос Гичгэний нурууг даваад баруун урагш уулсын хавцлаар явсаар Эрдэнэ сумын Хулсана ам хүрнэ.

2. Уйгурын үеийн худалдааны замын маршрут:



Энэ судалгааны үр дүнд Монгол нутгаар Торгон замын умард сүлжээ дайран өнгөрч тэрхүү замаар олон орны худалдаачид аялан явж байсан нь аяллын тэмдэглэл болох бичгийн дурсгалууд болон археологийн олдворуудаар нотлогдоод байна. Энэхүү умард замын сүлжээгээр дамжин монгол нутагт оршин байсан нүүдэлчид Торгон замын худалдаанд томоохон үүрэгтэй оролцож байсныг тодруулснаараа Торгон замын хөгжил дэх монголчуудын оролцоог үгүйсгэдэг үзлийг баримтаар няцаахад тодорхой хувь нэмэр болно гэж үзэж байна.

Бидний зураглан гаргасан энэхүү умард замын сүлжээний маршрутыг ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр шинээр хийж буй “Торгон замын дагуух орнуудын зам харилцаа, үйлдвэрлэлийн технологи,соёл, шашины харилцан нөлөөлөл, үйлчлэлийн атласт” Торгон замын хөгжилд Умардын нүүдэлчдийн оролцоо, зам харилцаа уламжлалт технологи, шашин соёлын талаар тодорхой мэдээллийг оруулах боломжтой юм.

2. ТОРГОН ЗАМЫН ХӨГЖИЛД ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ (XIII-XVI зуун) /20xx/ Эрхэлсэн Ц.Цэрэндорж

Хамтын бүтээл нь Удиртгал, долоон бүлэг, гурван зүйл, төгсгөл,ном зүйгээс хэсгээс бүрднэ. Бүтэц нь дараах байдалтай.

ГАРЧИГ

1. Удиртгал
2. Их Монгол улс ба Торгоны зам /С.Цолмон/
3. Хархорум ба Торгоны зам /С.Цолмон/
4. Юань улс ба Торгоны зам /А.Пунсаг/
5. Алтан Ордны улс ба Торгоны зам /С.Цолмон/
6. Цагадайн улс ба Торгоны зам /Ц.Энхчимэг/
7. Ил хант улс ба Торгоны зам /Л.Ганбат/
8. Монголын эзэнт гүрэн ба Торгоны зам /С.Цолмон/
 - А. Торгон зам ба зоос
 - Б. Торгон зам ба шашин
 - В. Торгон зам ба нохой /Г.Батболд/
9. Төгсгөл
10. Номзүй

Уг хамтын бүтээлд Евразийн уудам тал нутгийг хамарсан их Торгон замын олон зууны түүхийг дэлхийн олон эрдэмтэд олон шинжлэх ухааны зааг уулзварт тал талаас нь нухацтай судалсан боловч Торгон замын хөгжилд монголчуудын оролцоо, хувь нэмрийн тухай асуудал бараг судлагдаагүй орхигдсон гэж үзэж болно. Энэ нь 1990-ээд оноос өмнөх түүх бичлэгт Чингис хаан болон Монголын эзэнт гүрний түүхийг судлах нь хязгаарлалттай байсантай холбоотой.

Тиймээс “Торгон замын хөгжилд умардын нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр”(VI-XVI зуун) суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд Торгон замын хөгжил дэх монголчуудын оролцоо, тэдний оруулсан хувь нэмрийг тодруулан гаргахыг зорьсон юм. Тус хамтын бүтээлд дэвшүүлсэн шинэ санаа, баримт, дүгнэлтүүдээс товч дурдвал:

Хархорум хот нь өгүүлэн буй үед Евразийн улс төр, худалдаа, соёл, шашин, гадаад харилцааны гол төвүүдийн нэг, Торгон замын нэг томоохон зангилаа болж байжээ. 2004 онд Хархорум хот нь Орхоны хөндийн дурсгалуудын хамт ЮНЕСКО-гийн дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн нь олон орны эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж хамтарсан малтлага судалгаа хийгдэж байгаа бөгөөд судалгааны үр дүн нь бидний энэхүү бүтээлд чухал эх сурвалж болсон юм.

Монгол хаад өртөө болон торгоны замыг ивээлдээ авч аюулгүй байдлыг нь хангаснаар худалдаачид Солонгосын хойгоос Газрын дундад тэнгис хүртэлх уудам газар нутагт өргөн хүрээтэй худалдаа арилжаа хийж байсныг шинэ баримтад тулгуурлан судлан тодрууллаа.

Алтан ордны улсын газар зүйн байршил нь Монголын эзэнт гүрний баруун хязгаарт өрнө, дорныг холбох заагт оршиж байснаараа давуу талтай байв. Тиймээс бараа таваарын хангалтыг тасалдуулахгүйн тулд эзэнт гүрний нийслэл Хархорум, Дадугаас Алтан ордны нийслэл Сарай хот хүртэл 200 хонож ирдэг тэмээн жингийн цувааг ар араас нь тасралтгүй явуулж бараа таваарын хангалтын асуудлыг шийдвэрлэхэд худалдаачдад зээл өгөх, урамшуулал олгоход анхаарсан нь зөв шийдэл байжээ.

Монголын эзэнт гүрний нутаг дэвсгэр өргөжих тусам дорно, өрнийн соёлын харилцан нөлөөллөөр өвөрмөц өнгө төрхтэй хотууд хөгжиж эхлэв. Тэдгээр хотууд нь өмнөх үеийнхээс цар хэмжээ, хүн амын бүрэлдэхүүн, зохион байгуулалтын хувьд ялгаатай байв. Нийт эзэнт гүрний хэмжээгээр Дайду, Шанд, Алмалиг, Бухар, Самарканд, Ургенч, Марага, Султание, Сарай, Хажитархан зэрэг худалдааны томоохон хотууд, Каффа, Тана зэрэг тэнгисийн боомтууд, газар тариалангийн баян бүрд хотууд цэцэглэн хөгжиж тэдгээр хотуудад худалдааны том зах, худалдаачдын байрлах хороолол, гар урлалын төв, тусгай зөвшөөрлөөр мөнгө, зоос үйлддэг газрууд төвлөрч Монгол төрийн хатуу хяналт дор үйл ажиллагаагаа явуулж хуурамч мөнгө зоос үйлдсэн тохиолдолд хуулийн хатуу шийтгэл хүлээлгэж байсныг эх сурвалжийн баримтаар харуулсан болно.

Уг хамтын бүтээлд Монголын эзэнт гүрний үед монголын их хаадын дэмжлэгээр Торгон замын хөгжил оргил үедээ хүрч Торгон зам нь дан ганц худалдааны зам бус тухайн үед соёл, шинжлэх ухаан, зан үйл, техник, технологийн шинэ бүтээлүүд өрнө, дорнодод харилцан нэвтрэлцэх боломж нээгдснийг түүхэн эх сурвалж, тухайн үед аялан явсан элч төлөөлөгчдийн тэмдэглэл, газрын зургийн эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан шинэ баримт, гаргалгаа, дүгнэлтүүдийг хийж Торгон замын хөгжилд монголчуудын оруулсан хувь нэмрийг шинээр нэмэн тодруулсан.

Зөвхөн оруулсан хувь нэмэр ч бус Монгол хаад төрийн бодлогоор Торгон замын хөгжлийг дэмжснээрээ Евразид олон шинэ зүйлийг буй болгосныг тухайлбал төрийн удирдлага, гадаад харилцааны дэг ёсонд оруулсан өөрчлөлт болон Торгон замын дагуух улс орны зан заншил, хоол хүнс, хувцас хэрэглэл, шашин суртахуунд гарсан нийтлэг болон онцлог түүнд монголын төрөөс үзүүлсэн нөлөөллийн асуудлыг шинэ өнцгөөс судлан гаргахыг чармайсан болно.

Монголын эзэнт гүрэн буюу Юань, Алтан орд, Цагаадай, Ил хаант улсын үед Ази Европыг холбосон хамгаалалттай, амарч, үйлчилгээ авах боломжтой зам харилцааны болон мэдээллийн том сүлжээ байгуулж, худалдаа эдийн засаг, соёл шинжлэх ухааны ололт амжилт харилцан нөлөөлөх боломж бололцоог буй болгосныг бүрэлдэхүүний улс бүрийн онцлогийг харгалзан нарийвчлан авч үзсэн юм.

Эзэнт гүрний хэмжээнд эргэлдэж байсан гол бараа бүтээгдэхүүн нь монголчууд, тэр дундаа хаад ноёдын таалал, эрэлт хэрэгцээнээс шалтгаалж байсан тул тансаг хэрэглээний эд зүйлс чухал байр эзэлдэг байжээ. Чамин тансаг бөс бараа, торго, алт мөнгөөр урласан гоёл чимэглэлийн зүйлс монгол язгууртнуудын ихэд таалдаг зүйл байлаа. Эзэнт гүрэн тэлэхийн хамтаар шинэ шинэ бараа бүтээгдэхүүнийг сонирхох болж, өрнө дорнын худалдаанд тэдгээр бүтээгдэхүүнүүд голлох байр эзлэх болов. Тэдгээрийн дотроос гол чухлыг нь дурдвал, үнэт үслэг, шаазан, торго, бөс даавуу, агт морьд, цаас зэрэг болой. Эрэлт хэрэгцээнээс хамаарч Торгон замын салаа салбар ч нэмэгдсэн нь Харанхуйн оронтой үнэт үслэгийн арилжаа хийх болсон явдал байв.

Нэгэн төрийн удирдлагад орж улс, хот болгонд нэвтрэхэд төлдөг татвар үгүй болсноор барааны үнэ хямдран, таваарын эргэлт хурдасч орлого нэмэгдэв. Орлого нэмэгдсэнээр алт, мөнгөн зоосыг ихээр тээвэрлэх нь чирэгдэлтэй болсон учир Хубилай хааны зарлигаар цалин цагаан мөнгө, торгоор баталгаа болгосон цаасан мөнгө гаргасан нь худалдааг улам эрчимжүүлсэн ажээ.

Монголын эзэнт гүрний үед өрнөөс дорныг, дорноос өрнийг зорьсон Марко Поло, Ибн Батутта, Раббан Саума зэрэг аугаа их аялагчид төрөн гарч, хуурай газар, далай тэнгисээр дамжин дэлхийг тойрох аялал хийж олон худалдаачид аяллын тэмдэглэлээрээ газарзүйн шинэ шинэ нээлтүүдийг хийхэд хувь нэмрээ оруулсан билээ. Энэ нь хожим XV-XVI зууны “далайн их аялал”-ын урьдач нөхцөл болсон юм. Бас монголчуудын санаачилга, дэмжлэгээр хөгжин цэцэглэсэн одон орон судлал, хөлөг онгоц, луужин, газрын зураг гэх мэт мэдлэг, технологи нь дээрх алдарт аяллуудыг хийх чухал суурь нөхцөл болсныг дурдах нь зүйтэй. Христофор Колумб анх Энэтхэгийг зорин хөдөлсөн бус, европчууд Марко Пологийн аяллын тэмдэглэлээр дамжуулан мэддэг болсон гайхмаар баян тансаг орон болох Монголын эзэнт гүрнийг зорин гарсан нь эдүгээ нэгэнт тодорхой болоод байна.

Судалгааны үндсэн дүгнэлт:

Монгол хаадын санаачилга, дэмжлэгтэйгээр дэлхийн газрын зураг зохиогдох болсон нь хожмын газарзүй, тээвэр зам харилцааны ухааны хөгжилд чухал түлхэц өгсөн юм. Монголчууд бий болгосон цаасан мөнгөний нэгдсэн тогтолцоо нь хожим дэлхий даяар цаасан мөнгийг гүйлгээнд хэрэглэх үндэс суурь нь болжээ.


Монголын эзэнт гүрний түүхэн үүргийг нэг үе сөрөг талаас нь үнэлэх явдал давамгайлж байсан бол одоо аль болох бодитоор нь үнэлж дүгнэхийг дэлхийн олон орны эрдэмтэд оролдож байна. Ямартай ч, Монголын эзэнт гүрний түүх, үлдээсэн өв нь XX зуунаас өмнөх цаг үед оршиж байсан бусад эзэнт гүрэнтэй харьцуулахад, сөрөг талаасаа илүүтэйгээр эерэг талын нь жин давамгайлж, тухайн үедээ харьцангуй хөгжил дэвшлийг авчирч, хожим нь ч эерэг нөлөө нь зонхилж байсан нь түүхэнд баримттай үлдэж хоцорчээ.

Хоёр зууныг дамжин оршин тогтносон Монголын эзэнт гүрэн хүн төрөлхтөний түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн бөгөөд Өртөө болон Торгон замаар түгээсэн соёлын амжилт бүтээл, алдаа оноо нь эзэнт гүрний төрийг барьж байсан монголчуудад оногдох нь зүйн хэрэг юм.

Торгон замын хөгжилд Монгол төрийн бодлого, монгол хаадын авч явуулсан арга хэмжээнүүд нь нүүдэлчдийн оролцоо торгон замыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ үед торгон замын хөгжлийн оргил үе байсан гэсэн гол дүгнэлт үзэл баримтлалыг шинэ шинэ түүхэн эх сурвалж, мэдээ баримт, археологийн эх хэрэглэгдэхүүнээр тодруулан гаргасан болно.

Энэ нь Монголын эзэнт гүрний түүхийг шинээр авч үзэж буй өнөө үед судалгааны болон сургалт, танин мэдэхүйн ач холбогдолтой.

3. “Торгон зам ба нүүдэлчдийн соёл” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (12хх)



2019 оны 10-р сарын 11-ний өдөр зохион байгууласан тус хуралд ОХУ-ын болон БНСУ-ын эрдэмтэн судлаач оролцож нийт 20 гаруй судлаачийн 14 илтгэл хэлэлцүүлэв.

Илтгэлүүд:

1. Логистика чайного пути. С.Цолмон, доктор (Ph.D), проф (Түүх, угсаатны зүйн хүрээлэн Ц.П. Ванчикова., ИМБТ СО РАН. Доктор (S.D) исторических наук.)ОХУ

2. Хүннү ба Юэжи-гийн харилцаа Г.Эрэгзэн. Доктор, проф (ШУА-ийн Археологийн хүрээлэн)

3. Уйгур улсын үеийн Торгоны замын тухайд. А.Энхтөр. Доктор (Ph.D), дэд проф (ШУА-ийн Археологийн хүрээлэн)

4.Торгон зам ба монгол хаадын шашны зөрчил мөргөлдөөнийг тайван замаар шийдвэрлэх асуудалд. Ц.Энхчимэг Доктор (Ph.D), проф. (ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын Бага чуулганы ЭНБД)

5. Арслан суурьт суваргын учир. Р.Мөнхтулга. Доктор (Ph.D) (ШУА-ийн Археологийн хүрээлэн)

6. Баруунш зорчих зам дагуух руни бичгийн дурсгалууд. Ц.Баттулга. Доктор (Ph.D), проф. (МУИС-ийн ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим)

7. Гурван Мандалын руни бичгийн дурсгалд холбогдох тамга. Б.Азжая. Доктор (Ph.D). (МУИС-ийн ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим)

8. Хадны оршуулга ба Торгоны зам. С.Хүрэлсүх. Доктор (Ph.D). (ШУА-ийн Археологийн хүрээлэн)

9. “Улиастай хот ба Торгоны их зам”. Д.Баярсайхан. Доктор (Ph.D) , дэд проф. Улаанбаатарын Их сургууль, Түүхийн тэнхим.

10. Корйё-гаёо дуу Ссанхуажем Торгон замын худалдаатай холбогдох нь. Ян Хесүг. (БНСУ)Улаанбаатарын Их сургууль, докторант

11. Харбухын балгас. Л.Эрдэнэболд. Доктор (Ph.D). (ШУТИС-ийн Нийгмийн Технологийн Сургуулийн түүх, соёл судлалын профессорын баг)

12. Мэлхий толгой “Тогос” орд мөн үү? Т.Батбаяр. (ШУА-ийн Археологийн хүрээлэн)

13. Торгоны зам ба худалдааны цувааны зохион байгуулалтын асуудалд. Г.Батболд. (ШУА-ийн Археологийн хүрээлэн)

14. Хархорумын зуухнууд ба Торгоны замын дагуух технологи. Л.Мөнхбаяр. (ШУА-ийн Археологийн хүрээлэн)

Төслийн хүрээнд зохиогдсон энэхүү эрдэм шинжилгээний хуралд төслийн багаас найман хүн илтгэл хэлэлцүүлсэн байна.

Хуралд тавьсан илтгэлүүдийн гол агуулга нь дэлхийн хөгжлийн хандлага нь бүс нутагт чиглэсэн өнөө үед Евразийг холбосон “Нэг бүс, нэг зам”, “Талын зам”, “Цайны зам” зэрэг олон мега төслүүд эхэлж, Торгон замын уламжлал,

шинэчлэлийн асуудал олон орны эрдэмтдийн анхаарлыг татаж энэ үед монгол нутагт байсан худалдааны хотууд болон тэдгээрийг холбосон замууд байсныг түүх, археологийн баримтаар гарган тавьсан.

Евразийн улс орнуудыг холбож байсан гол шижим нь Торгоны зам, түүний олон салаа салбарууд байж, тэдгээр нь гагц худалдаа бус шинжлэх ухаан, гар урлал, техник технологи, шашин соёл түгэн тархах, харилцан нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэхэд умардын нүүдэлчид түүний дотор монголчуудын гүйцэтгэсэн үүргийг тодруулан гаргаснаараа сэн нь эрдэмтдийн олон жилийн судалгаагаар нэгэнт тодорхой болсон билээ. эртний монгол нутагт байсан худалдааны замууд болон худалдааны хотуудын тухай олон шинэ мэдээ баримт гаргаж тавьснаараа эрдэм шинжилгээний ач холбогдолтой.

Хоёр. Төслийн хүрээнд бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл:

1. Munkhbayar L., Tengis S., Saran S., Bemmann J Luminescence dating of an ancient walled settlement in Orkhon valley, Mongolia. Proceedings of the Mongolian Academy of Sciences. Vol. 57 No 04 (224) 2017.

2. Цолмон С. Торгоны замын сэргэлт ба худалдааны замууд (XIII-XIV)//- Journal of the Archaeology, History and Culture. Journal of the Ulaanbaatar State University, Mongolia. Volume 13(12) УБ.2017

3. Эрэгзэн Г. “Хүннү ба Юэжийн харилцааны асуудлыг түүх, археологийн хэрэглэгдэхүүнээр тодруулах нь” “Түүхийн судлал” 2017

4. Turbat, Ts. (2018) Xiongnu and Kantszyuy: Clarifying the forgotten history (Based on the pottery excavated from the 28th grave, Tamir river Red Cape) – in: Proceedings of the International Conference. The Silk Road and Nomads. Arkhangai aimag, 18-19 July 2018. – Ulaanbaatar, 2018: 57-80.

5. А.Энхтөр. “Төв Азийн нүүдэлчдийн хот суурины асуудалд”// Altaica УБ., 2018

6. Munkhtulga. R. Protection and preservation of the settlement sites in Mongolia./\ ACCU Nara International Correspondent. The Twentieth Regular Report. Vol. 20. Nara, 2018: 20-26

7. Төрбат, Ц. (2020) Хүннү ба Канцзюй: мартагдсан түүхийг тодруулах нь (Тамирын Улаан хошууны 28-р булшны ваарнаас сэдэвлэх нь). – Умардын үндэстнүүдийн археологи.- БНХАУ-ын Ардын их сургуулийн Умардын үндэстнүүдийн археологийн судалгааны хүрээлэнгийн сэтгүүл. 2020, №9 .

8. Цолмон С. “Торгон замын нүүдэлчид ба хоол хүнсний уламжлалт технологи” Хэвлэлтэнд. УБ.2019

9. Ганбат Л. “Монголын эзэнт гүрний үеийн Бага Азийн бүс нутгийн худалдааны тухайд” . Хэвлэлтэнд УБ.2019

10. Цолмон С. “Торгон зам ба үнэт үслэгийн хэрэглээ”- History, Archaeology and Ethnology. Улаанбаатарын их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. УБ. 2019

11. С.Хүрэлсүх. Торгоны зам ба соёлын солилцоог илтгэх нэгэн дүрслэл. History, Archaeology and Ethnology. Улаанбаатарын Их Сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. УБ.2019

Гурав. Төсөлт ажлын хүрээнд тавигдсан эрдэм шинжилгээний илтгэл:

1. Turbat, Ts. (2018) Presentation of the Rock art of Mongolia. – Round table and field workshop “Petroglyphs of Central Asia: perspectives of nomination of the rock art sites of Central Asia for the World Heritage List of UNESCO” (in frames of the International scientific and practical conference «Central Asia on the Great Silk Road: dialogue of cultures and confessions from the antiquity to present time»). 14-15 June 2018, Almaty, Kazakhstan. International Institute for Central Asian Studies by the UNESCO Silk Road Project.

2. Төрбат, Ц. (2018) “Торгоны замын дагуух соёлын харилцааны интерактив атлас бүтээх шинжээчдийн уулзалт: Идээ ундааны соёл”. 2018 оны 7-р сарын 16-17. Баянговь, Өвөрхангай аймаг. ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, ЮНЕСКО-гийн Торгон замын онлайн платформ. (Ts. Turbat. “Expert Meeting on the Development of an Interactive Atlas of Cultural Interactions along the Silk Roads: Food and Gastronomy”. 16-17 July 2018. Bayangobi, Uvurkhangai province. Mongolian National Commission for UNESCO / Silk Roads Online Platform of UNESCO)

3. Turbat, Ts. (2018) Middle Asia and Hunnu: Connections within the Sphere of Nomadic Civilization. – “The Silk Road and Nomads”. International Conference. 18-19 July 2018. Tsetserleg, Arkhangai province. International Institute for the Nomadic Civilizations / Institute of History and Archaeology, MAS.

4. Enkhtur A. Urbans OF SILK ROAD in UIGHUR and LIAO empire. International Symposium on Medieval Capitals, Grassland Silk Road and Khitan-Liao Culture to Commemorate the 1100th Anniversary of the Founding of Liao shangjing. China 2017.

5. А.Энхтөр ОХУ-ын Хакасын нийслэл Абукаан хотноо 2017 оны 8 сард зохион байгуулагдсан Монгол, Хятадын археологичдын хамтарсан эрдэм шинжилгээний хуралд “Уйгурын харуулын цамхагуудын сүлжээ” гэдэг илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн.

6. А.Энхтөр ОХУ-ын Хакасын нийслэл Абукаан хотноо 2017 оны 8 сард зохион байгуулагдсан Монгол, Хятадын археологичдын хамтарсан эрдэм шинжилгээний хуралд “Уйгурын харуулын цамхагуудын сүлжээ” гэдэг илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн.

7. А.Энхтөр. Уйгур, Хятаны үеийн Торгон замын дагуух хотууд. “Нүүдэлчид ба хот суурин” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар, 2018.08.24-25

8.А.Энхтөр. Торгон замын дагуух хот суурин. “Торгон замын ба нүүдэлчид” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. Архангай, Цэцэрлэг хот, 2018.

9. А.Энхтөр ОХУ-ын Улан-удэ хотноо 2017 оны 12 сард зохион байгуулагдсан “Төв Азийн Археологи-Этнографийн тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Уйгурын хот суурины онцлог” илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн.

10.Р.Мөнхтулга. Уйгурын үед Өтүкэнээс Торгон зам хүрдэг байсан замын тухай.“Ази судлал” олон улсын эрдэм шинжилгээний дөрөвдүгээр хурал. Улаанбаатар, 2017.05.18. Ази судлал. Volume IV. УБ., 2018: 493-500

11.Р.Мөнхтулга. VIII зуунд Өтүкэнээс Бэшбалык хүрдэг байсан зам. Руни бичгийг тайлж уншсаны 125 жилийн ойд зориулсан “Түрэг судлал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар, 2018.06.03. Köktürk Yazısının Okunuşununun 125. Yılında Orhun’dan Anadolu’ya Uluslararası Türkoloji Sempozyumu. Bildiriler Kitabı. 2. Cilt. İstanbul, 2018: 1104-1119

12.Л.Мөнхбаяр. Бага Нарийны амны төмрийн зуух. “Төмөрлөгийн түүх” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. Төв аймаг, Мөнгөнморьт, 2018.09.04-05, (Э.Пүүлийн хамт).

13.Л.Мөнхбаяр. Лүнгийн дөрвөлжингийн он цагийн тухай асуудалд. “Сяньби, Жужаны түүх, соёлын судалгаа” эрдэм шинжилгээний хурал. 2018.10.24

14. G.Batbold. 南戈壁省“成吉思汗界壕”历史时期考.International Symposium on Medieval Capitals, Grassland Silk Road and Khitan-Liao Culture to Commemorate the 1100th Anniversary of the Founding of Liao shangjing. China 2018.

15. Г.Батболд. Нүүдэлчдийн ахуй ба нохой. “Төв Азийн Археологи-Этнографийн тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.

16. Ц.Энхчимэг “Чингис хааны овгийн тамга Монголын эзэнт гүрний улс төрийн соёлын үндэс болох нь” СпБ.2018

17. С.Цолмон “Торгон зам ба Хархорум” -“Торгон зам ба нүүдэлчид” олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан.УБ.2018

18. Л.Ганбат “Монгол, түрэгийн адууны соёлтой холбогдох нэгэн зан үйлийн тухайд” илтгэлийг тус тус тавьсан болно. БНХАУ-ын Өвөр Монголын Үндэсний их сургуулиас зохион байгуулсан “Нэг бүс, нэг зам” Угсаатны зүйн олон улсын анхдугаар хурал (2019.10сарын 13-14)) БНХАУ. Тунляо

19. Ц.П. Ванчикова Доктор (Ph.D), проф С.Цолмон. Логистика чайного пути.- “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурал. УБ.2019

20. Г.Эрэгзэн. Хүннү ба Юэжи-гийн харилцаа. “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурал. УБ.2019

21. Г.Батболд. Торгоны зам ба худалдааны цувааны зохион байгуулалтын асуудалд. “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурал. УБ.2019

22. Р.Мөнхтулга. Уйгурын үеийн Орхоны хөндийгөөс баруун тийш чиглэсэн цэргийн зам-“Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурал. УБ.2019 .

23. А.Энхтөр. “Уйгурын хаант улсын торгон зам ба хот суурин”- “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурал. УБ.2019

24. С.Хүрэлсүх. Торгоны зам ба хадны оршуулга “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурал. УБ.2019

25. Т.Батбаяр. Мэлхий толгой “Тогос” орд мөн үү? “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурал. УБ.2019

26. Л.Мөнхбаяр. Хархорумын зуухнууд ба Торгоны замын дагуух технологи.-“Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” эрдэм шинжилгээний хурал. УБ.2019

27. С.Цолмон “Монголчуудын уул усны тахилга: уламжлал, шинэчлэл”- БНХАУ-ын Өвөр Монголын Үндэсний их сургуулиас зохион байгуулсан “Нэг бүс, нэг зам” Угсаатны зүйн олон улсын анхдугаар хурал (2019.10 сарын 13-14) БНХАУ.Тунляо.


28. А.Пунсаг”, “Монголчуудын архи уух зан үйлийн тухайд”- БНХАУ-ын Өвөр Монголын Үндэсний их сургуулиас зохион байгуулсан “Нэг бүс, нэг зам” Угсаатны зүйн олон улсын анхдугаар хурал (2019.10сарын 13-14)) БНХАУ.Тунляо

29. С.Цолмон “Монголын эзэнт гүрний худалдаа” (Алтан ордны улсын жишээгээр)- “Mongol Diaspora in Northeast Asia”. БНСУ-ын монгол судлалын олон улсын эрдэм шинжилгээний хурал. БНСУ.Чээжү. (2019.11 дүгээр сарын 1-3)

30. С.Цолмон “Хархорумаас Сарайд хүрч байсан замууд” (XIII зуун) илтгэл тавьсан. (2019.11 сарын 16-17) БНХАУ.Бээжингийн Төвийн үндэстний их сургуулиас зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал. Бээжин. 2019

Тав. Эрдэм шинжилгээний бусад ажил:

1. С.Цолмон БНХАУ-ын Бээжин хотноо 2017 оны 5 сарын 31-нээс 6 сарын 1-нд ЮНЕСКО-гоос зохион байгуулсан “Торгон замын дагуух улс орнуудын олон улсын соёлын харилцан нөлөөлөл, харилцан үйлчлэлийн Атласыг хөгжүүлэх Экспертүүдийн уулзалтанд оролцож монгол улсаас ямар зарчим баримталж яаж оролцох талаар харилцан ярилцаж “Торгон замын хөгжилд умардын нүүдэлчдийн оролцоо ба хувь нэмэр” сэдвийн дор монголын төлөөлөгчид саналаа нэгтгэж өгсөн.



2. Торгон замын хөгжилд нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр “Монгол орон ба эрт ба дундад үеийн Евразийн сүлжээ / Mongolia and the Eurasian Network in the Ancient and Medieval periods. Уб., 2018, 192 тал” хамтын бүтээл хэвлүүлсэн. (С.Цолмон, Ц.Төрбат нар эрхлэн хэвлүүлсэн ба тус бүтээлд Ц.Төрбат Торгон замын түрүү үе, Ц.Төрбат Их Торгон зам, Р.Мөнхтулга Түрэг улс ба Торгон зам, Р.Мөнхтулга Уйгур улс ба Торгон зам, С.Цолмон Монголын эзэнт гүрэн ба Торгон зам, Цолмон Торгон замын зоос, С.Цолмон Хубилай хаан ба Марко Поло, С.Цолмон Торгон зам ба шашин

гэсэн сэдвүүдийг тус тус бичсэн байна. Мөн хамтын бүтээлд орох олдворын гэрэл зураг, дурсгалын тухай тайлбар, мэдээллийг А.Энхтөр, Ц.Төрбат, Г.Эрэгзэн, А.Пунсаг, С.Хүрэлсүх, Р.Мөнхтулга, Т.Батбаяр, Л.Мөнхбаяр, Г.Батболд нар бичиж бэлтгэн 2018 оны 7 сард хэвлүүлсэн.

3. Р.Мөнхтулга МУИС-иас хэвлэн гаргасан Монголын эзэнт гүрний 5 боть зохиолд “Цагадай хант улсын соёл” гэсэн бүлгийг бичиж хэвлүүлсэн. Уг бүлэгт Цагадайн улсын соёлд Торгон зам ямар ач холбогдолтой байсан тухай дурджээ.

4. С.Цолмон Магистрант М.Бямбарагчаа “Сэцэн хан аймгийн эрх засгийн хошууны түүхийн зарим асуудалд”, Б.Амгаланбат “XIII-XIV зууны үеийн Монголын хүн чулуудын дүрслэл, он цагийн зарим асуудалд” сэдэвт магистрын 2 дипломын ажилд албан ёсны шүүмж бичив.

5. Р.Мөнхтулга түүхийн ухааны докторын зэрэг амжилттай хамгаалсан ба А.Пунсаг, Ц.Энхчимэг нар профессор цол хүртэв.

6. 2018 оны 6 сарын 21-нд Ц.Энхчимэг Монголын радиогийн нэвтрүүлэгт оролцож, Марко Пологийн “Орчлонгийн элдэв сонин” хэмээх хүнд хэлүүлж бичсэн аян замын тэмдэглэл европчуудын газар зүйн их нээлтийн үндсэн эх сурвалж болох нь сэдвээр ярилцлага өгөв.)

7. 2018 оны 04-р сарын 10-ны өдөр Р.Мөнхтулга SBN телевизийн “Түүхэн хэлхээ” нэвтрүүлэгт оролцож Эртний Түрэгийн угсаа гарал, соёл, нийгмийн талаар яриу.

8. 2018 онд Түүх, археологийн хүрээлэнгээс Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизээр цувралаар явуулж буй “Түүхэн хэлхээ” нэвтрүүлэгт А.Энхтөр, Ц.Төрбат, Р.Мөнхтулга, Ц.Цэрэндорж, А.Пунсаг, Ц.Энхчимэг, Л.Ганбат, С.Цолмон нар оролцож Эрт, дундад үеийн Монголын түүх, Эзэнт гүрэн, Торгон замын түүх, соёлын талаар яриу.

9. Шинжлэх Ухаан Технологийн сан-2018 сэтгүүлд Түүх, археологийн хүрээлэнгээс хэрэгжүүлж байгаа Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр” (VI-XIY зуун) төслийн явцын тухай С.Цолмон товч мэдээлэл хэвлүүлсэн.

Зургаа. Семинар

1. А.Энхтөр. Торгон замын дагуух дундад эртний хот суурин. Шүүмжлэгч: доктор, профессор С.Цолмон. ШУА-ийн нэгдсэн I байр 4 давхрын хурлын танхим. 2018.10.10
2. Р.Мөнхтулга. “Түрэгийн хожуу улс, Уйгур улсын үеийн нэгэн замыг тодруулах нь”. Шүүмжлэгч: доктор Б.Батсүрэн. ТАХ-ийн онол аргазүйн семинар. 2018.09.26
3. Л.Мөнхбаяр. “Хархорум хотоос олдсон зоос мөнгөний зүйлс”. Шүүмжлэгч: доктор А.Пунсаг. ТАХ-ийн онол аргазүйн семинари, ШУА-ийн нэгдсэн I байр 4 давхрын хурлын танхим. 2018.10.17

Долоо. Орчуулга

1. “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг (VI-XIV зуун)” суурь судалгааны төслийн тодорхойлолтыг 2018 оны 10-р сарын 08-09-нд англи хэлнээ орчуулав. (Гүйцэтгэгч: Р.Мөнхтулга)

Нийт :

1. “Их Торгон замын умард сүлжээ” (VI-XVI зуун) хамтын бүтээл. (15хх.)
2. “Торгоны замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг (XIII-XIVзуун)” хамтын бүтээл.. (20хх)
3. “Торгон зам ба нүүдэлчдийн соёл” эрдэм шинжилгээний хурал 2019 оны 10-р сарын 11-ний өдөр зохион байгуулав. Тус хуралд ОХУ-ын болон БНСУ-ын судлаачид оролцсон нийт 20 гаруй судлаачийн арван дөрвөн илтгэл хэлэлцүүлэв. (10 х.х.)
4. Эрдэм шинжилгээний өгүүлэл 13 бичиж хэвлүүлэхээс 15-ийг бичиж 13-ийг хэвлүүлсэн ба 2 нь хэвлэлтэнд байна.
5. Эрдэм шинжилгээний илтгэл 15 тавьж хэлэлцүүлэхээс 29 илтгэл тавьсан
6. Археологийн хээрийн шинжилгээний тайлан 3
7. “Монгол орон ба эрт ба дундад үеийн Евразийн сүлжээ / Mongolia and the Eurasian Network in the Ancient and Medieval periods. /24 х.х./ УБ., 2018 хэвлүүлсэн
8. “Торгон замын дагуух улс орнуудын олон улсын соёлын харилцан нөлөөлөл, харилцан үйлчлэлийн Атлас”-т орох нүүдэлчдийн хоол хүнс, гастрономын асуудлаар ярилцах ЮНЕСКО-гийн олон улсын экспертүүдийн уулзалт ярилцлага зохион байгуулсан. 2018. 7 сар
9. “Торгон зам ба нүүдэлчид” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монголын ЮНЕСКО-ийн Үндэсний комисс, Нүүдлийн соёл иргэншил судлах хүрээлэн, Олон улсын Монгол судлалын Холбоо, УИХ-ын Тамгын газартай хамтран зохион байгуулсан 2018. 7 сар

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

"ТОРГОН ЗАМЫН ХӨГЖИЛД ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ" СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ХҮРЭЭНД 2017-2019 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАНГИЙН ТОВЧ

Төслийн удирдагч:

С.Цолмон доктор (Ph.D), профессор, Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

Төслийн гүйцэтгэгчид:

А.Энхтөр доктор (Ph.D), дэд профессор, Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Л.Мөнхбаяр Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан

Т.Батбаяр Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан

Г.Батболд Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан

Захиалагч байгууллага: БСШУСЯ, ШУА, Түүх, археологийн хүрээлэн

Тайлан өмчлөгч: Түүх, археологийн хүрээлэн.

13343 Улаанбаатар, Жуковын гудамж-77

ШУА-ийн нэгдсэн I байр

Утас: 458305/455028

Цахим шуудан: info@history.mas.ac.mn

Улаанбаатар 2020

"ТОРГОН ЗАМЫН ХӨГЖИЛД ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ" СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ХҮРЭЭНД 2017-2019 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

Судалгааны ажил гүйцэтгэсэн газар: – Архангай, Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Завхан аймгуудын нутаг дахь эрт, дундад үеийн хот сууринууд, тэдгээрийн ойр орчмын дурсгалт газрууд

Судалгааны ажил гүйцэтгэсэн хугацаа: – 2017-2019 он

Гүйцэтгэсэн ажил: – Монголын төв, умард нутаг дахь эрт дундад үеийн хот сууринууд, тэдгээртэй холбогдох дурсгалуудыг баримтжуулж суурь судалгааны сэдэвт ажлын эх хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх

Судалгааны багийн бүрэлдэхүүн: – Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд профессор А.Энхтөр, тус салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), Р.Мөнхтулга, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Т.Батбаяр, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Л.Мөнхбаяр, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Батболд.

Үндэслэл, зорилго:

Монголын эрт, дундад үеийн хот сууриныг судалсан зүйл багагүй боловч энэ бүс нутагт үлэмж их ач холбогдолтой байснаар барахгүй, Монголын нутагт аж төрөн сууж байсан нүүдэлчин ард түмнүүдийн нийгэм, соёлд гүн их нөлөөгөө үзүүлсэн Их Торгон зам лугаа манай улсын нутаг дахь хуучны суурин газрууд чухам ямар холбоо хамааралтай байсныг шинжлэн нягталсан зүйл энэ хэр бараг үгүй гэхэд болно. Тиймээс бид Төв Азийн бүсээс өөр газар үйлдсэн бүтээгдэхүүнүүд Монголын нутагт буй археологийн дурсгалуудаас улам ихээр олдсоор байгаа баримтад тулгуурлан хэдэн мянган жилийн турш Ази, Европ, Африкийн ард түмэн, улс орнуудыг холбож байсан худалдаа харилцааны гол сүлжээ болох Торгон замтай манай бүс нутаг чухам ямар харилцаатай байсныг тодруулахыг эрмэлзэхийн хамт Төв Азийн хот сууринуудыг торгон замын дагуух хот сууринуудтай харьцуулах, Монголын нутаг дахь хот сууринуудыг холбосон зам харилцааг тодруулах, Монголын нутаг дахь хот сууринуудын үүрэг, зориулалтыг тодруулах, хот сууринаас олдсон шинэ олдвор хэрэглэгдэхүүн, мэдээллээр торгоны замтай холбоотойгоор харилцан нэвтэрсэн худалдаа, соёлын мэдлэгийг баяжуулах, тэдгээрийг академик түвшинд боловсруулан системчилж үнэн бодот мэдлэг бүтээхийг зорилго болгосон юм.

2017 оны хээрийн шинжилгээ: (эх тайлан 28 хуудас)

Судалгааны ажил гүйцэтгэсэн газар: Монгол улсын төвийн бүс нутаг Төв, Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгийн нутаг дахь эрт, дундад үеийн хот сууринууд, тэдгээрийн ойр орчмын дурсгалт газрууд

Судалгааны ажил гүйцэтгэсэн хугацаа: 2017оны 09 сарын 25-наас 10 сарын 10

Гүйцэтгэсэн ажил – Монголын төв, умард нутаг дахь эрт дундад үеийн хот сууринууд, тэдгээртэй холбогдох дурсгалуудыг баримтжуулж суурь судалгааны сэдэвт ажлын эх хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх

Суурь судалгааны сэдэвт ажлын эхний бүрдэл хэсэг болох судалгааны эх хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх ажлын хүрээнд энэ оны ажлыг гүйцэтгэв.

Хээрийн судалгааны багийн гишүүд Монгол улсын төвийн бүс нутаг Төв, Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгуудын нутагт орших эртний хот суурины үлдэл, турь болон тэдгээрийн орчмын дурсгалт газруудад ажиллаж археологийн хээрийн судалгааны баримтжуулалт хийв.

Бид энэ удаагийн богино хугацааны хээрийн судалгаагаар Монголын төв, умард бүсийн хот сууринууд, тэдгээртэй шууд холбоо бүхий бусад төрлийн дурсгалуудыг баримтжуулах ажлыг гүйцэтгэлээ.

Анх 1889 онд Хаант Оросын Газарзүйн Нийгэмлэгийн Орхоны шинжилгээний анги Монголын эрт, дундад үеийн хот сууринуудыг харьцангуй иж бүрнээр баримтжуулснаас хойш манай улсын нутаг дахь хот суурины судалгаа тасралтгүй өрнөн хөгжсөөр 20-р зууны дунд үеэс үндэсний судлаачид өөрсдөө бие даан судлах болсон билээ.

Гэвч хот суурины археологийн судалгаагаар олон жилийн турш зориуд бэлтгэсэн мэргэжлийн судлаачид өөрийн орны хот балгад, тэдгээрийг холбосон эртний зам харгуй зэргийг гаднын улсын этгээдтэй хамтралгүйгээр бие даан судлах нөхцөл бүрдэхгүй байсаар асар удсан юм. “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” суурь судалгааны сэдэвт ажлын нэгэн зорилт болох эрт дундад үеийн хот сууринууд, тэдгээрийн сүлжээг нэхэн тодруулах хээрийн шинжилгээний энэ жилийн ажлыг ийнхүү багахан хугацаанд амжилттай хийж гүйцэтгэлээ.

Бид Төв, Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай таван аймгийн нийт 57 дурсгалт газар археологийн баримтжуулалт хийж гүйцэтгэсэн нь энэ суурь судалгааны сэдэвт ажлын мэдээллийн санд үндсэн эх хэрэглэгдэхүүн болон орж байна.

Монголын эрт дундад үеийн хот суурин, тэдгээрийг холбосон зам харилцаа нь Евразийн Их Торгон замтай хэрхэн холбогдож байсныг цаашид лавшруулан тодруулахад бидний цуглуулсан эх хэрэглэгдэхүүнүүд чухал баримт болох нь дамжиггүй юм.



Цантын тур-Сэлэнгэ Орхон Байбалык хотын тур-Булган, Хутаг-өндөр



Зүүн бэлийн оршуулгын газар Заг Зуугийн балгас



Эрдэнэ уул



Лүн толгой

2018 оны хээрийн шинжилгээний тайлангийн товч (эх тайлан 22 хуудас)

Судалгааны ажил гүйцэтгэсэн газар: Булган, Өвөрхангай аймгийн нутаг дахь эрт, дундад үеийн хот сууринууд, тэдгээрийн ойр орчмын дурсгалт газрууд



Судалгааны ажил гүйцэтгэсэн хугацаа: 2018 он 9 сарын 26- 10 сарын 05

Гүйцэтгэсэн ажил: – Монголын төв, умард нутаг дахь эрт дундад үеийн хот сууринууд, тэдгээртэй холбогдох дурсгалуудыг баримтжуулж суурь судалгааны сэдэвт ажлын эх хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх

Монголын эрт, дундад үеийн хот суурин Торгон замтай хэрхэн холбогдох талаар авч үзэхдээ бид Монголын нутаг дахь VI-XIV зууны үед холбогдох хот суурин, булш оршуулга зэрэг археологийн дурсгалуудаас илэрсэн олдворуудыг системтэйгээр баримтжуулан тайлбарлаж торгон замын дагуух дундад эртний хот суурины олдворуудтай харьцуулах, Монголын нутаг дахь хот сууринуудын бүтэц, байгуулал, архитектурын онцлогийг торгон замын дагуух хот сууринуудынхтай харьцуулах, Монголын нутаг дахь хот сууринуудын дэд бүтцийг археологийн баримт, сурвалжийн мэдээгээр тодруулах, Монголын нутаг дахь хот суурины “төв”, “дагуул”-ыг тогтоох, түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн засаг захиргаа, нутгийн хязгаарын тухай мэдээг хот суурины байршилтай тулгаж зам харилцаа, суурин газрын тухай мэдээллийг газрын зурагт байршуулах зорилтыг дэвшүүлсэн.


Тухайн зорилтын хүрээнд Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум орчмын дурсгалын бүртгэл мэдээлэлийн нягтлах, шинэ дурсгал илрүүлэн, Монгол нутагт оршдог Чингисийн хэрэм хэмээх дурсгалд малтлага судалгаа хийх, зохион байгуулалтыг олж тогтоох ажлуудыг гүйцэтгэв.

Булган аймгийн Бүрэгхангай орчимд буй Чингисийн хэрмийн судалгаа Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь Эмгэнт уулын шороон далангийн байгууламж хэрхэн үйлдсэн, хэлбэр хэмжээ, үүрэг зориулалтийг тодруулах зорилгоор багахан хэмжээний малтлага хийлээ. Энэхүү хэрэм нь харагдах байдлын хувьд Чингисийн далантай адил урт үргэлжилсэн шороон далан юм. Одоогийн байдлаар уг шороон далан нь Туул голын хөндийд орших Хятаны хот суурингуудыг алсуур тойрсон шинжтэй байна. Өөрөөр хэлбэл Төв аймгийн Заамар сумын нутагт орших Хэрмэн дэнжийн балгасны ар талаар Заамарын хөндийгөөр баруун тийш чиглэж, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутгаар дайрч Эмгэнтийн хэрмийн араар дайрч баруун тийш Архангай амийгийн Өгийнуурын зүүн эрэгт тулж буйг одоогоор тогтоогоод байна. Иймээс уг далангийн өндөр, сувгийн гүнг тодорхойлох зорилгоор Эмгэнтийн хэрмийн ард Зараа толгойгоос 200-300 м зайд урагш чиглэсэн хэсэгт 50 см x 7 м хэмжээтэй сорилын малтлага хийлээ.



Хархорум Дунд булгийн шинээр олдсон дурсгалт газрын судалгаа

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Хархорум музейн хамтран ажиллах /2016-2018/ санамж бичгийн хүрээнд “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” суурь судалгааны сэдэвт ажлын эх хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх төсөлт ажлын хүрээнд 2018 оны 09-р сарын 27-ноос 10-р сарын 07 хүртэлх хугацаанд Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхон, Эрдэнэ толгой багийн нутаг Хархорум хотын туурь, Дунд булаг хэмээх газарт археологийн малтлага, хайгуул судалгааны ажил хийж гүйцэтгэв. Тус шинээр илэрсэн дурсгалт газар Хархорин сумаас зүүн урагш ойролцоогоор 5 км зайд орших Дунд булаг хэмээх газар эртний оршуулгын газар буйг мэдээллийн дагуу шалгаж, 111 булшны байршлыг тогтоон дурсгалт газрын дэвсгэр зургийг үйлдэж, он цагийг тогтоох зорилгоор хоёр булш малтан судаллаа.



Дунд булагийн оршуулгын газрын дэвсгэр зураг

Энэ жилийн малтлага судалгаагаар нийт 2 (41, 47-р булш) дурсгалыг сонгон малтав. 41-р булшнаас оршуулга илэрсэн нь баруун талын хананд тусгайлан зассан модон авсанд хөмөглөн оршуулсан бол 47-р булшнаас хүний оршуулга илрээгүй.

Мөн 41, 47-р булшнаас бог, бод малын зүдэлсэн хойлог, оршуулганд дагалдуулсан шавар сав суулгын эд зүйлс нь харьцангуй бага хөндөгдсөн байдлаар илэрч байна.

2019 хээрийн шинжилгээний тайлангийн товч. (эх тайлан 34 хуудас)

Судалгааны ажил гүйцэтгэсэн газар:– Завхан аймгийн нутаг Улиастай хот тэдгээрийн ойр орчмын дурсгалт газрууд

Судалгааны ажил гүйцэтгэсэн хугацаа – 2019 оны 09-р сарын 26-наас 10-р сарын 05

Гүйцэтгэсэн ажил: – Монголын төв, умард нутаг дахь эрт дундад үеийн хот сууринууд, тэдгээртэй холбогдох дурсгалуудыг баримтжуулж суурь судалгааны сэдэвт ажлын эх хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх “Торгон замын хөгжилд Төв Азийн нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг” төслийн хүрээнд Дундад зууны үеийн торгон замын сүлжээ ямар замаар хагуур явж өнгөрдөг байсан хийгээд нүүдэлчдийн улсын ямар хот сууриныг дайрч байсны археологийн судалгааны үүднээс тодруулахыг зорьж байгаа биллээ. Төслийн гурав дахь жил Монгол улсын баруун бүс дэх торгон замын сүлжээтэй холбоотой байж болох Улиастай хотын Сангийн хэрмэнд сорилтын малтлага хийллээ.

Завхан аймгийн Улиастай хотын баруун хойно Богдын гол Чигэстэйн голын бэлчирын дээд тал тууш дөрвөлжин зохиомжтой шороон далан бүхий хэрэм байна. Энэ хэрмийг Сангийн хэрэм хэмээн нутгийнхан нэрлэдэг ажээ. Эл хэрмийн талаар судлаач Д.Баярсайхан, Р.Мөнхтулга, Б.Амгаланбаатар нар өөрсдийн санал дүгнэлт бүхий өгүүлэл илтгэлийг хэвлүүлсэн байна.

Сангийн хэрэм. Хэрмийн зохион байгуулалт баруунаас зүүн тийш хандуулан тууш дөрвөлжин зохиомжтой байгуулжээ. Хэрмийн баруун ханын урт 410 метр Хойд ханын урт 515 метр, хэрмийн хана сууриараа 15 метр өргөн, өндөр нь 1-1.5 байна. болон урд хана мөн 515 метр хана тус бүрд нэг нэг сонор хаалга гаргасан ба хаалга хэрмийг бүтэн тойруулж 2-2.5 метр гүн, 12 метр өргөн суваг татсан байна. Энэхүү хэрмийн зүүн талд сувагийн гадна талтай залгуулан нэг хэрмийн туурь байна. Энэ хэрмийн зүүн болон урд хана мэдэгдэж байна. Зүүн ханын урт 410 метр өмнөд ханын урт 450 метр, ханын өргөн

Сорилын малтлага судалгаа-1 Бид их хэрмийн урд хаалганы Баруун талд хэрмийг зүсэж үзлээ 1,5x2м хэмжээтэй сорилийн суваг малтлаа. Малтлагын явцад шавар хэрмийн гадна талаа 120 см өргөн 80 см өндөр чулуун өрлөг илэрлээ. энэ өрлөгөөс 1 метрийн зайд 18x20 см голчттой хар модыг босоогоор нэг шулуунд эгнүүлэн суулгасан ор хоёр газраас илэрлээ. Хоорондоо 6 метрийн зайтай юм. Энэ хэрмийг барьсан үндсэн арга бололтой юм.



Сорилын малтлага судалгаа-2

Хэрмийн зүүн талд залган барьсан хэрмийн зүүн хананд 1x1 метрийн хэмжээтэй сорилт малтлага хийллээ. Малтлагаар шатаж уйлайсан нурам түүний хажуугаас 15-18 см голчтой хөрс модыг босоогоор зоосон хашааны ёзоор илэрлээ. Эндээс бид дээж авч шинжилгээнд илгээгээд байна. Хэрэв дээрх судлаачдын дүгнэлт болох Фүтүчэнь хот буюу дурсгалын он цаг нь Уйгурын үе хэмээн гарвал. Фүтүчэнь хот түүнийг тойрсон салаа замууд болно.

Фүтүчэнь хот нь Уйгурын баруун тийш худалдаа арилжаа наймаа хийх томоохон хот бөгөөд стратегийн хувьд Уйгурын баруун талын хамгийн чухал хот байжээ. Мэдээж хэрэг энэ худалдаа арилжааны том хот байсан учир бараа бүтээгдэхүүнийг авч ирж дахин борлуулах экспорт хийдэг хот байжээ. Учир нь Фүтүчэнь хот Бэйтин хоттой ойр, эртний торгоны замтай шууд нийлэх боломжтой хот юм. Энэхүү хотод нүүдлийн соёлтой улсуудаас хоёр чиглэлээр бараа бүтээгдэхүүн авч ирэх буцаагаад эл хоёр чиглэлээр суурин соёл иргэншилтэй улс руу бараа бүтээгдэхүүн авч ирдэг байжээ. Энэ нь торгоны их зам буюу Ази, Европыг холбосон арилжаа наймааг явуулдаг чухал замын сүлжээний нэг юм.



Дүгнэлт

Монголоос илэрдэг дундад зууны үеийн холбогдолт археологийн дурсгалын дотор хот суурины дурсгал зонхилж байдаг. Түүхийн сурвалж бичиг, археологийн мэдээгээр манай улсын нутагт уйгур, кидан, монголын эзэнт гүрний үед холбогдох гуч гаруй хот мэдэгдэж байна.

Тухайн цаг бүрд холбогдох хотууд Торгоны замын сүлжээнд өөрийн хувь нэмрийг оруулж байсныг судалгааны үр дүнгүүд улам тодорхой болгож байна. Торгоны замын сүлжээнд хамгийн өргөн дэлгэр хэмжээтэй оролцоо Уйгурын эзэнт гүрний үед хамгийн тод томруун харагдаж байна.

Уйгурын хаант улсын үед худалдаа арилжаа өргөн дэлгэрч жинхэнэ утгаараа торгон замын гол сүлжээ Монголын өндөрлөгөөр дайрч байсныг харж болохоор байна. Ялангуяа Тан улсад гарсан Ан лу шаны бослогыг дарсны дараа Уйгурын хаант улс худалдаа арилжаанд оролцох улс төр, эдийн засгийн өндөр боломж

үүсэж Торгон замын худалдааг гартаа оруулж авсан гэж хэлж болно. Энэ үед уламжлалт Ганьсу-н зам нь худалдаа арилжаа явуулахад хүндрэлтэй болж Тангудын дээрэмчид ихэссэн бөгөөд худалдаа арилжаанаас авах татвар, замын аюулгүй байдал алдагдаж эхэлсэн тул Уйгурын нутгаар аюулгүй явж болох нөхцөл бий болсон. Мөн Уйгур Тангийн хооронд хийсэн адууны арилжааны гэрээ их нөлөөлсөн байна. Энэ нь нүүдлийн болон суурьшмал соёл иргэншилтэй улсуудын соёлын харилцан нөлөө худалдаа арилжаагаар дамжин нэвтэрч байсныг археологийн дурсгалууд, олдворууд гэрчилж байна. Монгол нутагт байгуулсан Уйгурын хотууд баян чинээлэг сүр хүчтэй хотууд байсан талаар Араб худалдаачин жуулчдын тэмдэглэлд тодорхой тэмдэглэгдсэн байна.

Харин Хятан улсын үед археологийн дурсгалын хувьд Монгол нутаг Хятанд эзлэн захирагдсан хязгаар нутаг байсан тул үндсэн Хятан хүн ам төдийлэн суурьшин сууж байгаагүй, харин нутгийн эзлэгдсэн уугуул хүн амыг дарангуйлан захирах засаг захиргааны болон дарангуй цэрэг суух хотуудыг байгуулж худалдааны зорилгоор удаан хугацаанд ашиглаж байсныг харж болно. Хятан улсын хаан Елюй Абаожи 923 онд Монгол нутагт довтлон орж Уйгурын Хар балгас хүрсэн байна. Тэр цагт Монгол нутагт хот байгуулж цэрэг суулгаагүй бөгөөд харин Х зууны хоёрдугаар хагасаас Орхон, Хэрлэнгийн сав газрын олон аймгуудыг “урвах, дагах нь хязгааргүй” гэж тэднийг дарангуйлан захирах бодлого явуулж эхэлжээ.

805 оноос хойш Торгон замын уламжлалт их зам Ганьсу-н коридор худалдаа арилжааны байдал тасалдалд орж 25 жил орчим худалдаа арилжаа хийхээ байж Уйгурын нийслэл Орду балыкт ирж худалдаа арилжаа хийсэн байдаг.

Судалгааны явцад хот суурины хамгийн их тархалт, төвлөрөл Орхоны хөндий, Туул голын сав дагуу буйг олж тогтоосон бөгөөд тухайн үедээ торгон замын худалдааны том төв болж өргөжин хөгжиж, эндээс олон салаа зам гарч арилжаа худалдааны бүтээгдэхүүнийг тасралтгүй хангах бүхий Ази Европыг холбосон худалдаа арилжааны тогтвортой том сүлжээ болж хувирсан бөгөөд нүүдэлчдийн газар орноо таниж мэдэх мэдлэг тээврийн хувьд шинэчлэл гаргасан бөгөө маш хурдтай тээвэрлэх дамжуулах явдал нь энэ олон сүлжсэн зам харилцааг хөгжүүлэхэд түүхэн урагш ахисан үзүүлэлт болжээ.

Тухайн хот сууриныг холбох эртний Торгоны замын сүлжээнд оруулах, газрын зурагт буулгах, урьдач судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд, зарим он цаг нь маргаантай хотуудад малтлага судалгаа хийж эрдэм шинжилгээний хариулт өгөх тус төслийн үндсэн зорилт байсан болно.

Тайлан бичсэн:

Сэдэвт ажлын удирдагч

док.проф.С.Цолмон